

## **РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ӨРСӨЛДҮҮЛЭН ШАЛГАРУУЛЖ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Радио долгионы тухай хуулийн 11.4-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд өрсөлдүүлэн шалгаруулалтаар Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Өрсөлдүүлэн шалгаруулалтаар нийтийн үйлчилгээнд олгох радио давтамж, түүний ашиглалтын зориулалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос зарлана.

### **Хоёр. Өрсөлдүүлэн шалгаруулах хэлбэр**

2.1 Өрсөлдүүлэн шалгаруулалтыг доорхи хэлбэрээр явуулна. Үүнд:

- Үнэ хаялцуулах;
- Уралдаант шалгаруулалт.

2.2 Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг өрсөлдүүлэн шалгаруулж олгохдоо техник, технологийн иж бүрдлийг нь цогцоор нь шийдэх тохиолдолд уралдаант шалгаруулалт, техникийн шийдэл байхгүй тохиолдолд үнэ хаялцуулах ажиллагааг тус тус зохион байгуулна.

### **Гурав. Зохицуулах хороо**

3.1 Үнэ хаялцуулах болон уралдаант шалгаруулалтын ялагчийн талаархи эцсийн шийдвэрийг Зохицуулах хороо гаргана.

3.2 Ижил радио давтамж ашиглахаар хэд хэдэн этгээд байгаа эсэхийг улсын хэмжээнд гардаг өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр тодруулж, ирүүлсэн хүсэлтийг үндэслэн өрсөлдүүлэн шалгаруулж, хүсэлтийг шийдвэрлэнэ.

3.3 Материал боловсруулах ажлын хэсэг тогтоосон хугацаанд материалын иж бүрдэл, түүнд тавигдах болзол, шалгуурыг боловсруулж, Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрт заасан хугацаанд үнэ хаялцуулах болон уралдаант шалгаруулалтын зарыг шалгаруулалтын ажиллагаа явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө улсын хэмжээнд гардаг өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

3.4 Үнэ хаялцуулах болон уралдаант шалгаруулалтын материал боловсруулах болон үнэлгээний ажлын хэсгийг Зохицуулах хорооны даргын тушаалаар батална.

3.5 Үнэ хаялцуулах болон уралдаант шалгаруулалтын материалыг зохион байгууллагчийн санхүүгийн асуудал хариуцсан ажилтан сонирхогч этгээдэд холбогдох журмын дагуу олгоно.

3.6 Үнэ хаялцуулах болон уралдаант шалгаруулалтанд оролцохоор тогтоосон хугацаанд ирүүлсэн материалыг Зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хүлээн авах эцсийн өдрөөр материал хүлээн авах ажиллагааг дуусгавар болгож, үнэлгээний ажлын хэсэгт хүлээлгэн өгнө. Үнэлгээний ажлын хэсэг ажлын 30 хоногийн дотор үнэлгээг хийж, дүгнэлтээ Хорооны хуралдаанд танилцуулж, эцэслэн шийдвэрлүүлнэ.

3.7 Зохицуулах хорооны хуралдааны шийдвэрийг үндэслэн, ялагч этгээдэд гэрээ байгуулах эрх олгосныг ажлын 5 өдрийн дотор мэдэгдэнэ.

3.8 Зохицуулах хороо нь тендерийн бичиг баримт хангалттай хэмжээнд бэлтгэгдсэн, зарлалыг зохих журмын дагуу мэдээлсэн, тендерт оролцогчоос тендер ирүүлэхэд тэгш боломж, хангалттай болон ижил хугацаа олгосон, мөрдвөл зохих хуулийг зөрчсөн эсэхийг үнэлгээний ажлын хэсгээс хянана.

3.9 Энэхүү журмын 3.8-ын дагуу хянаж, зөрчил илрүүлсэн тохиолдолд тендерийн вйл ажиллагааг зогсоож, зохих хуулийн дагуу тухайн вйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх эрхтэй.

### **Дөрөв. Үнэ хаялцуулах ажиллагаа**

4.1. Үнэ хаялцуулах ажиллагаа нь дуудлага худалдааны хэлбэрээр явагдана.

4.2. Зар нь ажиллагаа явуулах хэлбэр, газар, цаг хугацаа, анхны үнэ, оролцогчдыг бүртгэх, ялсан этгээдийг тогтоох журам болон бусад мэдээллийг агуулсан байна. Шаардлагатай тохиолдолд зард гэрээ байгуулах хугацааг заана.

4.3. Үнэ хаялцуулах шалгаруулалтанд оролцохоор санал ирүүлсэн 2-оос доошгүй хувь хүн, албан байгууллагуудын материалыг зарласан нөхцөл, болзолыг хангасан эсэхийг дуудлага худалдааны үнэлгээний ажлын хэсэг тогтоож, шаардлага хангасан этгээдийг үнэ хаялцуулах ажиллагаанд оролцуулна. Хэрэв зөвхөн нэг шаардлага хангасан санал ирүүлсэн бол дахин зарлах хүртэлх хугацаагаар үнэ хаялцуулах ажиллагааг хойшлуулна.

4.4. Үнэ хаялцуулах ажиллагаанд оролцогчид нь зард заасан хэмжээ, журмаар, заасан хугацаанд дэнчинг тавина. Үнэ хаялцуулах ажиллагаа явагдаагүй буюу түүнд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно. Ялсан этгээдтэй гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.

4.5. Үнэ хаялцуулах ажиллагааны анхны үнэ, дэнчингийн үнийг Зохицуулах хороо хуралдаанаараа хэлэлцэж тогтооно.

4.6. Дуудлага худалдаагаар үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.

4.7. Иргэний хуулийн 197-р зүйлд заасны дагуу үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээд болон үнэлгээний хэсгийн дарга, гишүүд нь үр дүнгийн тухай тэмдэглэлд, үнэ хаялцуулах ажиллагаа явагдсан өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд энэ тэмдэглэл нь гэрээний адил хүчинтэй байна. Ялсан этгээд нь тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл оруулсан дэнчингээ алдана. Үнэлгээний хэсгийн дарга гишүүд нь тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл нөгөө талын тавьсан дэнчинг хоёр нугалж, ажиллагаанд оролцсоноос учирсан хохирлыг дэнчингээс давсан хэмжээнд нь нөхөн төлөх үүрэгтэй.

4.8. Үнэ хаялцуулах ажиллагаанд ялагч нь мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 3 хоногийн дотор санал болгосон үнийг төлж, Тусгай зөвшөөрөл авах гэрээнд гарын үсэг зурж, тусгай зөвшөөрлөө авна.

4.9. Дурдсан хугацаанд санал болгосон үнээ төлөөгүй тохиолдолд гаргасан шийдвэрийг цуцалж, дараачийн өндөр үнэ санал болгосон хувь хүн, аж ахуйн нэгжид ялагчийн эрхийг шилжүүлнэ. Энэ тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

### **Тав. Уралдаант шалгаруулалт**

5.1. Уралдаант шалгаруулалт /цаашид “тендер” гэнэ/-ын урилгад тухайн радио давтамжийн ашиглалтын зориулалт, тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах болон тендер ирүүлэх хаяг, тендерийн үнэ, тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендер нээх хугацаа зэрэг мэдээллийг тусгаж, улсын хэмжээнд гардаг өдөр тутамын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

5.2. Тендерийн бичиг баримтыг түүнийг бэлтгэхэд зарцуулсан өртгөөр үнэлж, тендерт оролцохыг сонирхогчдод уг үнээр саадгүй олгоно.

5.3. Тендерийн үнийн доод хэмжээг Хорооны хуралдаанаар хэлэлцэж тогтооно.

5.4. Тендерийн материалыг тендерийн бичиг баримтад товлосон хугацаанд, заасан хаягаар, тогтоосон хэлбэрээр ирүүлнэ.

5.5. Тендерт оролцогч нь тендерт холбогдох аль нэг асуудлаар Зохицуулах хороотой зөвхөн бичгээр харьцана.

5.6. Зохицуулах хороо нь тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

5.7. Тендерийг энэхүү журмын 3.6-ын дагуу тендерт оролцогчдыг байлцуулан тендерт ирүүлсэн бүх тендерийг тендерийн бичиг баримтад заасан газар, товлосон хугацаанд нийтийн өмнө нээж, тавигдсан болзол шаардлагын дагуу шалгаж, тэмдэглэл үйлдээд битүүмжлэнэ.

5.8. Тендер шалгаруулалтанд зохион байгуулагч талаас оролцож буй этгээдүүд нь тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах тухай аливаа мэдээллийг тендерт оролцогч болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдолгүй хүнд задруулахыг хориглоно.

5.9. Тендерийн бичиг баримтын бүх нөхцөл болзол, ялангуяа тендерт оролцогчийн чадамж, техник, тоног төхөөрөмж нь тендерт бэлтгэх зааварчилгаанд заасны дагуу хүлээн зөвшөөрөхүйц эсэхийг шалгах нөхцөл болон техникийн тодорхойлолтыг биелүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн гэж үзнэ. Үнэлгээний хэсэг шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

5.10. Тендерийг үнэлэх, тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргах явцад тендерт оролцогчоос тендерийн үнэлгээний хэсэгт нөлөө үзүүлэх аливаа оролдлого нь түүнийг тендерт оролцуулахаас татгалзах үндэслэл болж болно.

5.11. Тендерт оролцогчдын материал нь шаардлага хангахгүй бол заавал шалгаруулалт хийх шаардлагагүй.

5.12. Тендерийн үнэлгээний хэсэг нь тендерт ирүүлсэн материалуудыг үнэлнэ. Тендерийг үнэлэхдээ тендерийн материалд ирүүлсэн үнийг үнэлгээний шийдвэрлэх шалгуур үзүүлэлт гэж тооцохгүй.

5.13. Тендерийн үнэлгээний хэсэг нь тендерийн нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх чадварыг хангасан буюу хамгийн их үнэлгээ авсан байдлаар жагсааж, шалгаруулалтын дүнг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.14. Тендерт ялагчийг тендерийн үнэ төлсөн баталгаа ирүүлсэн даруй хоёр тал гэрээнд гарын үсэг зурж, ажлын 5 өдрийн дотор бусад тендерт оролцогчдод шалгараагүй тухай мэдэгдэнэ.

5.15. Тендерт ялагч энэхүү журмын 5.14-р заалтыг биелүүлээгүй нь тогтоогдсон нөхцөлд гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгож тендер шалгаруулалтанд удаах байр эзэлсэн тендерт оролцогчид Тусгай зөвшөөрөл эзэмших гэрээнд гарын үсэг зурах эрх шилжинэ.

*/Энэ журамд 2004 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 16, 2007 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 23-р тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан./*

----- о О о -----